



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2002 оны 10 сарын 11 өдөр

Дугаар 290


Улаанбаатар хот


Гадаадад суралцуулах тухай

2002-2003 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2002 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Цэрэнжав овогтой Уранбилэгийг Австрали улсын Гриффит Их сургуулийн магистрантурт компьютерийн программ хангамжийн чиглэлээр 1,5 жилийн хугацаагаар, Цэгмид овогтой Гантөгсийг АНУ-ын Мүррэй Улсын Их сургуулийн магистрантурт цахилгаан холбооны системийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар 2002-2003 оны хичээлийн жилээс тус тус суралцуулсугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД  А.ЦАНЖИД



Зуувар унт, Сайдын тушаал
З. Энхтариал. 2002.10.11.